

БНХАУ байгуулагдсаны дараа ХКН ард түмнээ социалист байгуулалтын замаар удирдан, эвдэрч сүйрсэн хот суурины эдийн засгийг сэргээхийн зэрэгцээ хөдөөд газрын шинэтгэл хийж капиталист хувийн өмчийг нийгэмчлэн, орон даяар жинхэнэ соёлын хувьсгал өрнүүлээ. Хятадын ард түмний сонгож авсан энэ зам гарцаагүй зөв байсныг анхдугаар 5 жилийн төлөвлөгөөний жилүүд (1953—1957) дэхь Хятадын нийгэм-эдийн засгийн гол гогцоо асуудлыг шийдвэрлэхэд олсон ололт амжилт гэрчлэн харуулсан билээ. Харин намын дотор марксист-ленинист, тууштай интернационалч болон гуйвамтгай жижиг хөрөнгөтний урсгалын «хоёр шугам»-ын тэмцэл ширүүсч, шинэ шатанд шилжиж байлаа. 1949 оны хувьсгалын дараах Хятадын шинэ нийгмийн улс төрийн амьдралын ийм эгзэгтэй үед ХКН-ын өмнө улс төрийн стратеги бодлогоо боловсруулах хариуцлагатай зорилт тавигдсан юм.

1956 оны 9-р сарын 15—27-нд хуралдсан ХКН-ын VIII их хурал энэ зорилтоо нэр төртэй биелүүлж намын эгнээн дэх марксист-ленинист хүчний ялалт бэхжилтийг харуулж чадлаа. Чухам үүгээр л ХКН-ын VIII их хурлын түүхэн ач холбогдол тодорхойлогдоно. Их хурал дэвшилт хүн төрөлхтөний дэмжлэг, ЗХУ-ын бүх талын тусламж дэмжлэгтэйгээр хятадад хувьсгал ялж, тус орон социализмын замаар замнасан үеийн ололт амжилтыг нэгтгэн дүгнэжээ.

ХКН-ын VIII их хурал хуралдах тэр үед цөөнгүй алдаа гарч хүнд хэцүү, шийдвэрлэгдээгүй асуудал, ялангуяа намын үзэл суртлын ажилд. сэхээтний талаар явуулж байсан бодлогод, түүнчлэн намын дотоод амьдралд олонтаа тулгарч байсан хэдий ч их хурал гүн гүнзгий, ул үндэстэй зөв шийдвэр гаргасан юм»<sup>1</sup>

Социалист орнуудтай харилцан холбоотойгоор БНХАУ-д социализм байгуулах намын жанжин шугамыг бататган баталсан ХКН-ын түүхэн шийдвэр нь БНХАУ-ын социалист хэтийн төлөвийн төлөө тэмцэлд, Хятадын ард түмний хувь заяанд өнөө ч гэсэн чухал ач холбогдолтой хэгээр байна.

ХКН-ын VII их хурал (1945) хуралдсанаас хойш 11 жил өнгөрч, энэ хугацаанд олон улсын байдалд үндсэн том өөрчлөлтүүд гарч Хятадын ард түмний хувь заяанд ч эргэлт болжээ. ХКН-ын эгнээ түрүүчийн их хурлаас хойш бараг 9 дахин өсч 10 сая 730 мянган гишүүнтэй улс төрийн томоохон хүч болсон байлаа. Гэвч бүрэлдэхүүний хувьд тариачид зонхилсон нам хэвээр байв. 1956 онд ХКН-ын гишүүдийн 69%-ийг тариачид, 14%-ийг ажилчид 129%-ийг сэхээтэн, 5%-ийг хүн амын бусад давхарга эзэлж байжээ<sup>2</sup>. ХКН-ын эгнээний бүрэлдэхүүний ийм байдал тус намын практик үйл ажиллагаа улс төрийн бодлого үзэл сурталд зохих хэмжээгээр нөлөөлсөн юм.

<sup>1</sup> Ф. Бурлацкий. Мао Цзэдун и его наследники. М., 1980. с. 86.

<sup>2</sup> Материалы VIII всекитайского съезда КПК. М., 1956. с. 65.

Хятад дахь социалист байгуулалтыг ул үндэсгүй түргэтгэх, тухайлан үйлдвэрлэх хүчний шинж чанар, тухайн үеийн нөхцөл байдлыг үл харгалзан, эдийн засгийн хөгжлийг хурдасгах, ялангуяа хөдөө аж ахуйг түргэвчлэн хоршооллосон зэрэг үйл явдлууд ХКН-ын доторхи жижиг хөрөнгөтний үндсэрхэг хандлага хэвээр байж, заримдаа пролетарийн интернационалч хүчнийхэнээс давамгайлж байсныг харуулсан билээ. Мао Зэдун 1955—1956 онд олон тооны хаалттай болон бусад хурал зөвлөлөгөөн дээр энэхүү үндсэрхэг жижиг хөрөнгөтний байр суурийг олон удаа илэрхийлж байв.

Гэвч дэлхийн социалист систем үүсэн бий болж, олон улсын коммунист хөдөлгөөн эрч далайцтай өрнөж байсан тэр жилүүдэд ХКН-ын доторхи эрүүл саруул хүчнийхэн ХКН-ын VIII их хурал дээр ялан гарч буурай хөгжилтэй, хүн ам ихтэй асар том оронд социализм байгуулах онол, практикийн нарийн төвөгтэй асуудлыг зөв шийдвэрлэх, жижиг хөрөнгөтний урсгал байдал, их хан үндэстний дээрэнгүй үзлийн хүчтэй дарамтыг эсэргүүцэн няцаах боломж олж чадсан юм<sup>3</sup>.

Тэр жилүүдэд Хятадын хувьсгал, Хятад дахь социалист байгуулалтын ололт амжилтыг Мао Зэдун нэртэй холбон үзэж, улмаар нам төрийн гол бүх албан тушаалыг гартаа атгасан\* Мао Зэдунг тахин шүтэх хандлага нэгэнт бий болсон байлаа. Ийм нөхцөлд урьдах амжилт ололт, алдаа дутагдлаа бодитойгоор зааглан үзэх, байгаа бололцоо бэрхшээл саадыг эрүүл саруулаар үнэлэх, тус орны хөгжлийн хэтийн төлөвийг шинжлэх ухааны үндсэн дээр тодорхойлох чин эрмэлзлэл VIII их хурлийн уур амьсгалд зонхилж байлаа.

Их хурлын үндсэн илтгэлүүд, олон төлөөлөгчдийн хэлсэн үгэнд, түүнчлэн их хурлын шийдвэрт шүүмжлэл өөрийн шүүмжлэлийг өрнүүлэх, бие тоох, дур зоргоороо аашлах, бүдүүлэг авирлах, өөрийгөө хэт үнэлэх, олон түмэнтэй зөвлөлдөхгүй байх, санаа бодлоо бусдад тулган хүлээлгэх, нэр төрөө хадгалахын тулд алдаагаа хамгаалах явдлыг шүүмжлэн буруушаав. Жижиг хөрөнгөтний үндсэрхэг үзэл хүчтэй илэрч байсан нөхцөлд намын доторхи марксист ленинч хүчний ийм байр суурь чухал нөлөөтэй байлаа.

ХКН-ын VIII их хуралд 50 гаруй орны коммунист, ажилчны, хөдөлмөрийн болон ардын хувьсгалт намын төлөөлөгчид оролцсон<sup>4</sup> нь ерөөс ХКН-ын их хурлуудад гадаадын төлөөлөгч оролцсон анхны бөгөөд одоо хүртлэх цорын ганц хурал болж байгаагаараа онцлог юм.

ХКН-аас 1952 онд баталсан «нэлээд урт хугацааны дотор улс орноо аажмаар социалист ёсоор үйлдвэржүүлж, хөдөө аж ахуй, гар үйлдвэр, капиталист үйлдвэр, худалдааг аажмаар социалист ёсоор өөрчлөн байгуулах»<sup>5</sup>-аар заасан намын жанжин шугамын зөв зүйтэйг баталж, намын жанжин шугамыг хянан үзэх гэсэн жижиг хөрөнгөтний үндсэрхэг үзэлтнүү-

<sup>3</sup> История Китая с древнейших времен до наших дней. М., 1973. с. 460

\* Хятадад хувьсгал ялсаны дараа Мао Зэдун ХКН-ын дарга, БНХАУ-ын Ар Дын Төв Засгийн газрын дарга, Хятадын Ардын улс төрийн зөвлөлдөх зөвлөлийн байнгын хорооны дарга, Ардын хувьсгалт цэргийн зөвлөлийн дарга, 1954 онд БНХАУ-ын дарга болжээ.

<sup>4</sup> ХКН-ын III их хурлын баримт бичгийг 3 ботиор эмхэтгэн 1956 онд хэвлэн гаргажээ. Үүний 3-р ботид их хурал дээр гадаадын төлөө эгчдийн хэлсэн үг баяр хүргэлт, баярын цахилгаан зэрэг 61 баримт бичиг оржээ. Материалы VIII всеки тайского съезда КПК. т. 3. Пекин. 1956.

<sup>5</sup> Лю Шаоци ХКН-ын ТХ-оос Бүх Хятадын коммунист намын VIII их хуралд тавьсан улс төрийн тайлан илтгэл, УБ, 1956, 8-р тал.

дийн оролдлогыг няцаасанд ХКН-ын VIII их хурлын шийдвэрийн гол агуулга оршино.

Их хурал намын жанжин шугамын зөв зүйтэйг ХКН-ын шинэ дүрэмд заан тодорхойлсон төдийгүй, ЗХУ-ын тусламж дэмжлэгтэйгээр шинжлэх ухааны үндэстэй боловсруулсан БНХАУ-ыг 1958—1962 онд хөгжүүлэх II 5 жилийн төлөвлөгөөг баталсан байна.

Тус орны эдийн засгийн бодлогын үндсэн зорилтыг их хурлаас тодорхойлохдоо улс ардын аж ахуйг техникийн талаар шинэчлэхийн тулд зайлшгүй шаардагдах материаллаг баазыг бий болгох, ард түмний амьдралын түвшинг дээшлүүлэхийн тулд Хятад орны социалист ёсоор аж үйлдвэржүүлэх явдал гэж заасан байна. ХКН-ын Төв Хорооны улс төрийн тайлан илтгэлд: «социализм байгуулахын тул социалист үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь чухал бөгөөд юуны урьд манай орныг газар тариалангийн хоцрогдол орноос тэргүүний үйлдвэрийн орон болгохын тулд хүнд үйлдвэрийг хөгжүүлэх нь чухал юм. Харин ингэхэд нэлээд их цаг хугацаа хэрэгтэй байна»<sup>6</sup> гэжээ.

Их хурал Хятадад социализм байгуулах шилжилтийн үе нэлээд урт хугацаагаар барагцаалбал 3 таван жил түүнээс ч илүү үргэлжлэх нь зайлшгүй болохыг тодорхойлсон. Ингэхдээ их хурал Хятадын эдийн засгийг дэлхийн социалист эдийн засгийн нэгдмэл системийн нэг гэж үзээд БНХАУ-д аж үйлдвэрийг хөгжүүлэх нь социалист лагерийн орнуудын хооронд хоршооллыг бэхжүүлэх бүх социалист орнуудын эдийн засгийг нийтэд нь сэргээхэд тус дөхөм үзүүлэх чухал ач холбогдолтой гэж заажээ. Улс төрийн тайлан илтгэлд: «орон бүхний пролетари нарын эв санааны интернационалч агуу их нэгдэлгүйгээр олон улсын хувьсгалт хүчний дэмжлэггүйгээр манай оронд социализм ялах боломжгүй, яллаа ч гэсэн түүнийг батлуулах бололцоогүй» юм гэж тэмдэглэжээ.

Уг хурлын баримт бичгүүдэд тус орны бодит бололцоог хэтрүүлэн үнэлж байсан «зүүний балмад чиг шугамын аюул заналын тухай, хятадын хувьсгал социалист хувьсгалд урган орохыг үл зөвшөөрөн хүлээх, хот, тосгонд капитализмыг хязгаарлахыг үл хүсэгч «баруунтны» тухай ХКН, Хятадын ард түмэнд сануулсан юм. Энэ сануулга цагаа олсон, бүрэн зөв зүйтэй байсныг хожмын хэрэг явдлууд харуулсан билээ.

Хятадын эдийн засгийг хөгжүүлэх үндсэн асуудлаар их хурлаас гаргасан баримт шийдвэр Хятадад социализм байгуулах бодитой бодож, боловсруулсан үндсэндээ зөв чиг шугам байлаа.

Их хурал социалист орнуудтай эв нэгдэл, найрамдлаа бэхжүүлж империалист, харгис хүчний эсрэг, дайн түрэмгийллийн эсрэг идэвхтэй тэмцэн нийгмийн янз бүрийн байгуулалтай улс орнуудтай энх тайвнаар зэрэгцэн орших бодлого баримтлах нь БНХАУ-ын гадаад бодлогын чиг шугам мөн гэдгийг тодорхойлжээ. Их хурал дэлхийн II дайны дараах олон улсын байдлыг зөв үнэлж, хятадын бүтээн байгуулалтанд олон улсын таатай нөхцөл бүрэлдсэнийг онцлон тэмдэглэсэн билээ. Их хурлын баримт бичгүүдэд Хятадын хувьсгал, Хятад дахь социалист бүтээн байгуулалтанд үзүүлсэн ЗХУ болон социалист бусад орнуудын асар их тусламжийн талаар ах дүү орнуудын ийм нөхөрсөг тусламжийг Хятадын ард түмэн хэзээ ч мартаггүй, ийм тусламж урьд ч, одоо ч, ирээдүйд ч бидэнд чухал»<sup>7</sup> гэж тэмдэглээд социалист орнуудтай найрамдал, эв нэгд-

<sup>6</sup> Мөн тэнд

<sup>7</sup> ХКН-ын ТХ-оос Бүх ХКН-ын VIII их хуралд тавьсан улс төрийн илтгэл. УБ. 1956, 75-р тал.

лээ улам бэхжүүлэх зорилтыг ХКН, Хятадын ард түмний өмнө дэвшүүлсэн нь чухал ач холбогдолтой байлаа.

Их хуралд тавьсан Төв Хорооны улс төрийн тайлан илтгэлд: «Нийтийн зорилго, харилцан туслах зарчим дээр үндэслэсэн, Хятад ба Зөвлөлт Холбоот Улс болон социализмын бусад улсын найрамдал, нэгдэл мөнх бөгөөд эвдрэшгүй юм. Энэ эв нэгдэл, найрамдлыг улам бэхжүүлж хүчтэй болгох нь бидний хамгийн эрхэм интернационалч үүрэг бөгөөд манай орны гадаад бодлогын үндэс мөн»<sup>8</sup> гэж онцлон тэмдэглэжээ. Хятадын гадаад бодлогын ийм чиг шугам нь дэлхийн энх тайвныг хамгаалах, социализмын олон улсын нэр хүндийг өргөх, империализмын эсрэг дэвшилт бүх хүчний тэмцлийг нэгтгэх, улмаар империализм, харгис хүчний байр суурийг сулруулахад ч чухал ач холбогдолтой байлаа.

Бусад орны коммунист намуудтай тогтоосон харилцаагаа хөгжүүлж, намын гишүүдийг пролетарийн интернационализмын үзэл санаагаар хүмүүжүүлэх явдлыг VI их хурал ихээхэн анхаарч ХКН-ын шинээр ба талсан дүрэмд тодорхой тусгажээ.

БНХАУ социалист байгуулалтынхаа эхний 10 жилд социалист орнуудтай улс төр, эдийн засгийн нягт харилцаатайгаар, тэдний байнгын дэмжлэг тусламжийг авч, тэдэнтэй нэгэн эгнээнд явж капиталист орнуудтай энх тайвнаар зэрэгцэн орших зарчмыг хэрэгжүүлж байснаар тус улсын нэр хүнд, олон улсын байр суурь байнга өсч байлаа.

Их хурал намын амьдрал, намын байгуулалтын асуудлыг авч үзэхдээ ХКН-ын дотор пролетарийн биш аюултай хандлага байсаар ба гол аюул урьдын адил жижиг хөрөнгөтний урсгал байдлын даралт шахалт болохыг онцлон анхаарчээ. Энэ талаар ХКН-ын Төв Хорооны тайлан илтгэлд тэмдэглэхдээ: «Манай оронд жижиг хөрөнгөтнүүд дийлэнхи олонхи болж байна. Хөрөнгөтөн ангийн санаа сэтгэл бидэнд байнгын даралт, нөлөө үзүүлж байна. Хөрөнгөтнүүд янз бүрийн салбарт бидэнд үргэлж нөлөөлсөөр байна. Иймд манай намын улс төрийн батжилд хөрөнгөтний болон жижиг хөрөнгөтний үзэл суртал хор хөнөөл учруулах түйн тулд нам эгнээнийхээ дотор хүмүүжлийн ажлыг байнга явуулах хэрэгтэй гэж тэмдэглэжээ.

ХКН-ын VIII их хурал ЗХУКН-ын XX их хурлын тааламжтай нөлөөний дор хуралдсаныг Хятадын удирдагчид их хурал дээр нэг бус удаа тэмдэглэж байв. Их хурлын шийдвэрт хамтын удирдлагын зарчмыг хэлбэрэлтгүй сахиж, нэг хүнийг тахин шүтэхийн эсрэг тэмцэх нь чухал ач холбогдолтойг заан тэмдэглэжээ.

ХКН-ын дүрэмд өөрчлөлт оруулах тухай илтгэлд: «Нэг хүнийг тахиж шүтэх явдал бол нийгмийн урт удаан түүхтэй үзэгдэл мөн бөгөөд тэр нь манай намын болон нийгмийн амьдралд зарим нэг тусгалаа ололгүй өнгөрч чадсангүй. Бидний зорилт бол нэг хүнийг товойлгон мандуулахын эсрэг чиглэсэн Төв Хорооны чиг шугамыг цаашид шийдвэртэй хэрэгжүүлэхэд оршино...» гэж тэмдэглэж байв. Хамтын удирдлагын тухай, намын дотоод ардчиллыг хөгжүүлж нэг хүнийг тахин шүтэх аливаа илрэлтэй тэмцэхийн чухлыг Лю Шаоци, Пэн Дэхуай, Чжу Дэ нар их хурал дээр хэлсэн үгэндээ тэмдэглэж байжээ.

ХКН-ын VIII их хурлын үед ХКН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны гишүүн, БХЯ-ны сайд байсан Пэн Дэхуай хожим «соёлын хувьсгалын» үед баривчлагдаад байхдаа «1956 онд VIII их хурал дээр: би аливаа нэгэн байдлаар Мао Зэдуны үзэл санаанаас иш татахыг намын

<sup>8</sup> Мөн тэнд

дүрмээс хасах санал тавьсан. Намайг дөнгөж хэлэнгүүт Лю Шаоци энэ саналыг дэмжиж «Зөв! Бүгдийг л хасвал сайнсан» гэж хэлж байлаа» хэмээн өгүүлснийг Гонконгд хэвлэгдсэн нэлээд баттай эх сурвалжид тулгуурлан Унгарын нийтлэлч В. Ференц бичжээ.<sup>9</sup>

Ийм тэмцлийн чухал үр дүн нь намын үзэл суртлын үндсийн талаар ХКН-ын VIII их хурлаас баталсан намын шинэ дүрмийн томъёолол юм. Намын VII их хурлаас ХКН-ын үзэл суртал-онолын үндэс бол «Мао Зэдун үзэл санаа» Мөн гэж заасан заалтыг VII их хурлаар баталсан ХКН-ын шинэ дүрэмд оруулалгүй хасчээ.

Намын дүрэмд: «ХКН үйл ажиллагаандаа марксизм-ленинизмийг удирдлага болгоно. Гагцхүү марксизм-ленинизм нийгмийн хөгжлийн зүй тогтлыг зөв тайлбарлан социализм коммунизм байгуулах замыг зөв зааж байна» гэжээ. Энэ бол ХКН-ын доторхи марксист-ленинист хүчний байр суурийг илтгэн харуулсан чухал ялалт байлаа.

ХКН-ын VIII их хурлын түүхэн ач холбогдол нь ХКН-ын доторхи Интернационалч хүчний байр суурийг бэхжүүлэн, намын жанжин шугамыг таягдан хаях гэсэн жижиг хөрөнгөтний үндсэрхэг үзэлтний оролдлогыг няцааж, дэлхийн нийт социалист системтэй нягт холбоотойгоор Хятадад социализм байгуулах чиг шугамыг тодорхойлсонд оршино. Тус их хурлын шийдвэр үндсэндээ марксизм-ленинизмийн үзэл санаа, пролетарийн интернационализмын зарчимд нийцэж байлаа. Их хуралд олон улсын Коммунист ажилчны хөдөлгөөний олон тооны төлөөлөгч, тэр дундаа социалист орны төлөөлөгчид оролцсон явдал ХКН-ын доторхи интернационалч хүчнийхний байр суурьт зохих ёсоор нөлөөлснийг тэмдэглэх хэрэгтэй. Энэ утгаараа тус их хурал чухал ач холбогдолтой юм.

Хятад дахь социалист байгуулалтын хэтийн төлөвийг тусгасан Хятадын ард түмний хувьсгалт үзэл санаа, хөдөлмөрийн урам зоригийг урьд үзэгдээгүй ихээр бадруулжээ. Гэвч тухайн нөхцөл байдлын эрхээр их хурлын үед арга буюу түр ухралт хийсэн Мао Зэдун болон түүний талынхан ХКН-ын гол удирдлагад байснаа ашиглан их хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын тууштай арга хэмжээ авалгүй, харин ч ард түмнийхээ энэ их урам зоригийг ашиглан ХКН-ын VIII их хурлын шийдвэрээс огт өөр гадаад дотоод бодлогын чиг шугамыг ХКН, Хятадын ард түмэнд тулган хүлээлгэх болсон юм.

ХКН-ын доторхи Мао Зэдун тэргүүтэй жижиг хөрөнгөтний үндсэрхэг үзэлтнүүд VIII их хурлын чиг шугамын эсрэг шийдвэртэй тэмцэл өрнүүлэв. Энэ нь тус намын доторхи 2 шугамын тэмцлийн шинэ үе шатны эхлэл боллоо.<sup>10</sup>

ХКН-ын доторхи үндсэрхэг хүчний үйл ажиллагаа даамжран Хятадын нийгэм-эдийн засгийн хөгжилт, намын үйл хэрэгт хурц хямралт байдал бий болгосныг тус оронд болсон цаашдын хэрэг явдал харуулсан билээ. Энэхүү сунжирсан хямралын уршигт үр дагавар үргэлжилсээр улигт «соёлын хувьсгал» гэгчид хүргэсэн юм.

Хятадын удирдагчид гадаад бодлогын салбарт зөвлөлтийн эсрэг үзлийн үндсэн дээр империалист гүрнүүдтэй хамтран ажиллаж байгааг Олон улсын тавцанд явуулж ирсэн тэдний практик үйл ажиллагаа хамруулж байна. Социализм, энх тайван үйлсэд харшилсан ийм бодлого хятадын ард түмэн төдийгүй, дэлхийн социализмын үйлст ч хүнд ноцтой уршиг тарьсан юм.

<sup>9</sup> Варнай ференц. «Путь маоистов» М., 1979, с. 110

<sup>10</sup> Т. Н. Яценко. Идеологическая борьба в КНР (1957—1964). М. 1977 с. 14.

60-иад оны эхээр ХКН-ын доторхи сөрөг хүчнийхэн дэлхийн коммунист хөдөлгөөн, олон улсын амьдралын үндсэн асуудлаар үзэл суртал улс төрийн хувьд марксизм-ленинизмд харш төдийгүй шууд дайсагнасан онцгой чиг шугамаа гарган тавьсан юм. ХКН анги нэгт ах дүү намуудаас тасран хөндийрч, улмаар тэдний эсрэг дайсагнасан ажиллагаа явуулж байлаа.

ХКН-ын доторхи жижиг хөрөнгөтний үндсэрхэг үзэлтнүүд ийнхүү марксизм-ленинизмын зарчмыг таягдан хаяж, Хятадын социалист байгуулалтыг олон жилээр ухраан, Хятадын ард түмний язгуур эрх ашгийг хөсөрдүүлсэн юм. Чухам ингэж марксизм-ленинизмыг Мао Зэдуны үзэл суртлаар сольсон бөгөөд тэгэхдээ марксист ленинист нэр томъёог ашиглаж, марксизмын эсрэг бодлого явуулж байдгаар маоизмын хөнөөлт уршиг илэрхийлэгддэг.

ХКН-ын VIII их хуралд хуралдсанаас хойш 26 жилийн дотор ХКН 4 удаагийн их хурлаа хийсэн боловч тэр бүрийд «Мао Зэдуны үзэл санааг» нам төрийн үйл ажиллагааны үндэс болгон баталж байлаа. Тэтэл «Мао Зэдуны үзэл санаа» гэгч нь Хятадын хувьсгалын хөрөнгөтний ардчилсан шатанд ажилчин ангийн замын хань болж, үндсэрхэг үзэл суртлаа бэхжүүлэх замаар уг хувьсгалд батжиж авах, тэр үзэл суртлаараа ажилчин анги, коммунист намыг хордуулахыг оролдож байсан жижиг хөрөнгөтний хувьсгалчирхаг хүчний үзэл бодлын илэрхийлэл бөгөөд чухамхүү ийм хүчин л маоизмыг ХКН, Хятадын ажилчин ангид түр тулган хүлээлгэж чадсанд Хятадын хувьсгал, ХКН-ын эмгэнэлт явдал оршиож буйг Хятадын ард түмэн өнөөдөр ч биеэрээ үзэж байна.

Байгуулагдсан цагаасаа хойш нарийн төвөгтэй урт замыг туулахдаа ялалт, амжилт олж, ноцтой алдаж, эндэж ирсэн ХКН-ын түүхэн сургамж нь жижиг хөрөнгөтний үндсэрхэг дээрэнгүй хандлага ямар хүнд хор уршиг тарьж болохыг тодорхой харууллаа.

БНХАУ-ын улс төрийн амьдралд ил далд тэмцэл, эвлэрэл, түр зуурын буулт зэрэг хувьсил, өөрчлөлт гарсаар боловч Хятадад социализм байгуулах жанжин шугамыг боловсруулсан ХКН-ын VI их хурлын чиг шугам Хятадын социалист хэтийн төлөвийн төлөө тэмцэгч бүх хүчинд үйл ажиллагааны нь дайчин мөрийн хөтөлбөр болж байна.

ХКН-ын VIII их хурлын түүхэн шийдвэрийг Монголын коммунистууд, нийт хөдөлмөрчид санаа нэгтэй дэмжсээр ирсэн бөгөөд дэмжих ч болно.

«Ирээдүй хойчоо бодож үзэхэд ЗСБНХУ, Хятадын хамтын ажиллагааны нөөц асар их байна гэж хэлж болно. Тийм хамтын ажиллагаа хоёр орны эрх ашигт нийцэж байгаа учраас, манай ард түмнүүдийн хувьд социализм, энх тайван хоёр салж хуваагдашгүй хамгийн эрхэм учраас тийм асар их нөөц байгаа» тухай ЗХУКН-ын XXVII их хурал дээр ЗХУКН ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга М. С. Горбачевийн тэмдэглэсэнчилэн социалист ертөнцийн бусад орны хувьд ч БНХАУ, Хятадын ард түмэнтэй хамтран ажиллах, харилцааг хэвийн болгон хөгжүүлэх нөөц их байгаа нь тодорхой.